



АГААРЫН БОХИРДОЛ ба 2019 ОНЫ ТӨСӨВ

(тойм, дүгнэлт)

СУДЛААЧ: Б.ЭНХБАЯР

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО:

- Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын зорилтын биелэлт.
- Энэ хүрээнд 2011-2017 онуудад хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн мэдээлэл, гарсан үр дүн.
- 2019 оны төсвийн хүрээнд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээ, төсөв болон хүлээгдэж буй үр дүн.

АШИГЛАСАН МАТЕРИАЛУУДЫН ЭХ СУРВАЛЖ:

- 2019 оны УИХ-ын хуралд Сангийн Яамнаас өргөн барьсан төсвийн төсөл
- 2019 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл
- 2019 оны Сангийн Яамнаас боловсруулсан гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн танилцуулга
- 2011-2017 оны Монгол улсын төсөв, тодотгол, гүйцэтгэл
- 2018 оны улсын төсвийн тодотгол
- Үндэсний Статистикийн Хороо, цахим сан - 1212.mn
- Нийслэлийн Статистикийн газар, цахим сан - ubstat.mn
- Цаг, уур орчны шинжилгээний газрын цахим мэдээллийн сан **АГААРЫН ЧАНАРЫН ТАЙЛАН, МЭДЭЭ - tsag-agaar.gov.mn**
- Бусад эх сурвалжууд

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

1. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ /1992 он/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Арван зургадугаар зүйл.

2/ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;

2. МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ /2010 он/

3.4.3. Амьдрах орчны аюулгүй байдал

3.4.3.1. Иргэдийн амьдрах, ажиллах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний аюулгүй байдлыг баталгаажуулах чухал үндэс болно.

3.4.3.4. Томоохон хот, суурин газарт агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, ариун цэврийн байгууламжийн бүтээмжийг нэмэгдүүлж, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгоно.

3. МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030 /2016 он/

I үе шат (2016-2020): Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг боловсруулж, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг бий болгох, Улаанбаатар хот болон бусад хот, сууринг дахин төлөвлөх, барилгын дулааны алдагдлыг 20 хувиар бууруулах.

4. АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬ /2012 он/

6 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

6.1. Засгийн газар хүрээлэн байгаа агаар /цаашид “агаар” гэх/ хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. Агаар хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийг батлах, түүний хэрэгжилтийг зохион байгуулах;

6.1.2. Агаарын бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах, үйл ажиллагааны харилцан уялдааг хангахад хяналт тавих чиг үүрэг бүхий **Үндэсний хороо** байгуулж ажиллуулах;

6.1.3. Агаарын бохирдлыг бууруулахад шаардагдах төсвийн төслийг боловсруулж батлуулах;

6.1.5. Агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын цахилгаан дамжуулах, түгээх шугам сүлжээг өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих;

5. АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР /2017 он/

3.1. Хөтөлбөрийг 2017-2025 онд дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

3.1.1. нэгдүгээр үе шат: 2017-2019 он;

3.1.2. хоёрдугаар үе шат: 2020-2025 он.

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ХҮРЭЭНД БАЙГУУЛАГДСАН НЭГЖҮҮД /2011-2018/



Өмнөх бүтэц

Одоогийн бүтэц

2013 – 2017 ОНЫ ТӨСВИЙН ЗОРИЛТОТ ТҮВШИН

ЖИЛ БҮР ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ХӨТӨЛБӨРТ АГААРЫН БОХИРДЛЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗОРИЛТОТ ТҮВШИН:

2013 онд	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА 1.2. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагаа БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН САЙД 2012-2013 оны өвөл нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах /хувиар/	40%	тодорхойгүй
2014 онд	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Нийслэлийн агаарын бохирдлыг 2011 онтой харьцуулахад бууруулах хувь БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН САЙД Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах /хувь/	45% 10%	PM10- 20%↓ PM2.5- 16%↓ SO2- 7%↑
2015 онд	Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт 19.6.1. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах /хувь/ 19.6.2. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах /төсөл, арга хэмжээ/	10% 2 төсөл	PM10- 34%↓ PM2.5- 15%↓ SO2- 54%↑
2016 онд	Цэвэр агаарын санг 2016 оны 1 дүгээр сарын 1-нээр тасалбар болгон татан буулгаж чиг үүргийг салбарын яамд, орон нутагт шилжүүлэхээр тооцохоор болсон.	зорилтот түвшин байхгүй	
2017 онд	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД 18.6.1. Агаарын чанарыг сайжруулах бүсийг тогтоож, гэр хорооллын галлагаанаас үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулах /хувиар/	10%	PM10- 5%↑ PM2.5- 3%↑ SO2- 27%↓
2018 онд	18.5.1. Бохирдуулагч бодисын бууралт /сүүр түвшин-2016 оны 12 дугаар сарын дундаж/ /хувиар/ 18.5.2. Гэр хорооллын хэрэглэгчдэд шөнийн цахилгаан эрчим хүчний хөнгөлөлтөд хамруулах нөхцөлийг бүрдүүлэх /өрхийн тоо/ 18.5.3. Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхийг 2.5 кВт, 4 кВт-ын чадалтай цахилгаан халаагуураар халаах техникийн боломж бүрдүүлэх /шинээр хамрагдах өрхийн тоо/	5-10% 130,000 өрх 20,000 өрх	

Эх сурвалж: 2013-2018 Төсвийн тухай хууль. Цаг уур, орчны шинжилгээний газрын тайлан 2014-2017 он

ТӨСВӨӨС САНХҮҮЖИЛТ АВСАН ДҮН: /сая.төг/

I. ЦЭВЭР АГААРЫН САН /2011 - 2015/

2011		2012		2013		2014		2015		НИЙТ гүйцэтгэл
Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	
31,500.0	31,500.0	30,000.0	24,641.0	31,000.0	22,924.4	20,260.8	9,185.9	20,163.9	5,257.9	93,509.2

Санхүүжилтийн зарцуулалтыг агаарын бохирдлын эх үүсвэрүүдээр нь ангилж харвал:



Эх сурвалж: 2013-2015 Төсвийн тухай хууль. Цэвэр агаар сангийн тайлан.

ТӨСВӨӨС САНХҮҮЖИЛТ АВСАН ДҮН: /сая.төг/

II. НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРОО /2012 - 2014/

2012		2013		2014		НИЙТ гүйцэтгэл
Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	
86.4	85.8	136.6	114.3	233.9	188.9	389.0

Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо нь 2011 оны 6-р сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар байгуулагдаж, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран Улаанбаатар хотод хязгаарлалтын бүс тогтоож утаагүй түлш, утаа бага гаргадаг зуух тараах, агаарын бохирдлыг бууруулахаар, Монголын Мянганы Хөгжлийн Сорилтын сангаас хэрэгжүүлсэн сайжруулсан зуух тараах үйл ажиллагааг зохион байгуулагдах зорилгоор байгуулагдаж байсан.

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХАД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ /2012 – 2017 он/

	2011 гүй	2012 гүй	2013 гүй	2014 гүй	2015 гүй	2016 гүй	2017 гүй
Цэвэр агаарын сан	31,500.0	24,641.0	22,924.4	9,185.9	5,257.9		
Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо		322.6	315.1	479	426.5		
Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо						4,260.0	4,540.0
Агаарын бохирдлыг бууруулах							
НИЙТ УЛСЫН ТӨСВӨӨС	31,500.0	24,641.3	22,924.8	9,186.4	5,258.3	4,260.0	4,540.0

Эх сурвалж: 2013-2018 Төсвийн тухай хууль.

АГААР БОХИРДУУЛАГЧ ЭХ ҮҮСВЭРҮҮД:

УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМЫН ТОО: Жилийн дундаж өсөлт: 2.7%



ОРОН СУУЦ БА ГЭР ХОРООЛЛЫН ӨРХИЙН ТОО:




ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТОО: Жилийн дундаж өсөлт: 9.5%




АГААР БОХИРДЛЫН ХЭМЖЭЭ: /жилийн дундаж/

ТОМ ШИРХЭГТ ТООСОНЦОРЫН ХЭМЖЭЭ /PM10/:




2008.12.12-ны өдрөөс Улаанбаатар хотын агаарын бохирдлыг хэмжиж эхэлсэн.

ЖИЖИГ ШИРХЭГТ ТООСОНЦОРЫН ХЭМЖЭЭ /PM2.5/:



АГААР ДАХЬ ХҮХЭРЛЭГИЙН ХЭМЖЭЭ /SO2/:



Гэр хороолол, орон сууцанд амьдарч буй өрхийн тоог агаарын бохирдлын гол 3 үзүүлэлттэй харьцуулж харахад гэр хороололд амьдарч буй өрхийн тоо нь агаарын бохирдлын PM2.5, PM10, SO2 үзүүлэлтүүдтэй хамааралтай зүй тогтол ажиглагдаж байгаа боловч 2012-2015 онд гэр хорооллын айл өрхийн тоо нэмэгдсэн хэдий ч агаарт агуулагдах хортой үзүүлэлтийн хэмжээ буурсан 45-50 хувиар буурсан нь утааг буруулах талаар нэгжүүдийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн гэж тайлбарлаж болохоор байна.

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын тайлан 2014-2017 он

2011-2017 ОН /дүгнэлт/

- Нэгдсэн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр байхгүй.
- Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр батлагдсан хууль, тогтоомж, шийдвэрийн **хэрэгжилт тодорхойгүй** буюу хангалтгүй.
- Олон газар **олон нэгжүүд байгуулагдаж, үйл ажиллагааны уялдаа холбоогүй**, замбараагүй ажилласан, татан буугдсан.
- Албан ёсны мэдээ, мэдээлэл, тайлан, хийж хэрэгжүүлж байсан арга хэмжээнүүдийн талаарх **тоо баримт, мэдээлэл байхгүй**.
- 2016 онд Цэвэр агаарын сан-г татан буулгаснаар Улсын төсвөөс зарцуулах хөрөнгө, **санхүүжилтийн хэмжээ эрс буурч** 4-5 тэрбум болсон.
- 2016 оноос хойш агаарт агуулагдах хорт нэгдлийн хэмжээ буюу SO₂, PM_{2.5}, PM₁₀ нэгдлүүдийн түвшин буцаад **3-33% хүртэл хэмжээгээр нэмэгдэхэд** шууд бусаар нөлөөлсөн гэж үзэх үндэслэлтэй.
- Орон сууцанд амьдардаг бүртгэлтэй айл өрхүүдийн тоо жилд дундаар **5.6 хувиар буюу 5-8 мянгаар нэмэгдэж** байгаа.
- Гэр хороололд амьдардаг бүртгэлтэй айл өрхүүдийн тоо 2016 оноос эхлэн жил бүр **0.5-1.5 хувиар буурсан**.
- Нийслэл хотод бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тооны **өсөлт саарч 15-аас 7%** болсон нь тээврийн хэрэгслээс шалтгаалах бохирдлын эх үүсвэрийн өсөлтийг сааруулахад нөлөөлсөн байж болзошгүй.
- Агаарын бохирдлын эх үүсвэрийн талаарх **албан ёсны тоо баримт одоог болтол байхгүй** буюу 2014 онд НЗДТГ-аас гаргасан судалгааг 2019 оны төсвийн төсөлд БОАЖЯам ашиглаж байгаа.

2019 ОНЫ ТӨСӨВ ба АГААРЫН БОХИРДОЛ

2017 ОНД БАТЛАГДСАН “АГААР ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”:

Шалгуур үзүүлэлт		Нэгж	Суурь түвшин (он)	Зорилтот түвшин (он)	
			2016	2019	2025
Бохирдуулах бодисын бууралт (суурь үзүүлэлт 2016 оны 12 дугаар сарын дундаж)	PM2.5 тоосонцор	мкг/м ³	256	190	70
	PM10 тоосонцор	мкг/м ³	279	210	100
	Хүхэрлэг хий (SO ₂)	мкг/м ³	89	70	50

2019 ОНЫ УЛСЫН ТӨСӨВ: БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД

	Хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2019 оны зорилтот түвшин	Судлаачийн нэмэлт тайлбар
18.5.1	Бохирдуулагч бодисын бууралт /суурь түвшин-2016 оны 12 дугаар сарын дундаж/ /хувиар/	25.0	2016 оны байдлаар: PM10 - 255мкг/м3 PM2.5 - 243 мкг/м3 SO2 - 55 мкг/м3
18.5.2	Гэр хорооллын хэрэглэгчдэд шөнийн цахилгаан эрчим хүчний хөнгөлөлтөд хамруулах нөхцөлийг бүрдүүлэх /өрхийн тоо/	150,000	гэр хорооллын 75%-ийг хамруулсан байх
18.5.3	Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхийг 2.5 кВт, 4 кВт-ын чадалтай цахилгаан халаагуураар халаах техникийн боломж бүрдүүлэх /шинээр хамрагдах өрхийн тоо/	41,200	гэр хорооллын 20.5%-ийг хамруулсан байх

Эх сурвалж: СЯ 2019 төсвийн төсөл, Цаг уур, орчны шинжилгээний газар, 2016 оны ажиглалтын тайлан, ubstats.mn

2019 ОНЫ ТӨСӨВ ба АГААРЫН БОХИРДОЛ

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ЭХ ҮҮСВЭРИЙН ТУХАЙ:

Монгол улсын Засгийн газраас 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 98 дугаар тогтоолоор “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг батлан гаргаж, энэхүү хөтөлбөрийн хавсралтын 6.1-д Хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ, ажлыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ гэж заасан. Үүнд:

- 6.1.1. улсын болон орон нутгийн төсөв;
- 6.1.2. агаар бохирдуулсны төлбөрийн орлого;
- 6.1.3. ус бохирдуулсны төлбөрийн орлого;
- 6.1.4. олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж;
- 6.1.5. аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө;
- 6.1.6. бусад эх үүсвэр.

2019 ОНЫ ТӨСӨВ ба АГААРЫН БОХИРДОЛ

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ЭХ ҮҮСВЭР: /тэрбум.төг/

/сая.төг/

Эх үүсвэрүүд	Нэгдсэн төсөв	Улсын төсөв	Орон нутгийн төсөв
Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ /6.1.1/	143,764.7	94,578.6	49,186.1
Агаарын бохирдлын төлбөр /6.1.2/ - 50%	22,000.0		
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр /6.1.3/ - 50%	26,470.0		
НИЙТ ТӨСӨВ	154,878.2		



Эх сурвалж: Улсын төсвийн төсөл 2019. Сангийн яам

2019 ОНЫ ТӨСӨВ ба АГААРЫН БОХИРДОЛ

2019 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ:


	Зарцуулалт	Дүн /тэрбум/	Хамрагдах тоо хэмжээ
1	Гэр хорооллын өрхүүдийн шөнийн цахилгааны тарифын хөнгөлөлт	16.4	Тодорхойгүй. 2017-2018 онд 114.512 өрх хамрагдсан. /НЗДТГ/
2	Гэр хорооллын айл өрхүүдийн яндангийн шүүлтүүр	54.3	100,000 өрх буюу 50%
3	Улаанбаатар хотод ажиллаж байгаа уур зууханд филтер байрлуулах	22.5	3000 нам даралтын зуух
4	Сайжруулсан түлшинд татаас олгох	54.7	55,000 өрх буюу нийт өрхийн 27.4%
	НИЙТ	147.9	

Эх сурвалж: 2019 онд БОАЖЯамнаас Агаарын бохирдлыг бууруулах төсвийн зарцуулалт.

2019 оны Агаарын бохирдлыг бууруулах төсвийн зарцуулалтаас 2019 оны зорилтот түвшинд хүрэхийн тулд богино хугацаанд хэрэгжүүлж болохуйц, утааны ялгаралт, хорт агууламжийн хэмжээг бууруулах, гэр хорооллын айл өрхүүдийн нүүрсний хэрэглээг багасгахад илүүтэй чиглэсэн байна.


2019 ОНЫ ТӨСӨВ ба АГААРЫН БОХИРДОЛ

2019 ОНД ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР:



- Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр дэд бүтэц хөгжүүлэх, гэр хорооллыг хөгжүүлэх, орон сууцны барилгын чиглэлээр 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад **нийт 1,733.32 сая ам.долларын төсөвт өртөг бүхий 23 төсөлд 204.03 тэрбум төгрөгийн** төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр тусгасан байна.
- 186.94 тэрбум төгрөг нь зээл, 17.09 тэрбум төгрөг нь буцалтгүй тусламж хэлбэрээр байна.**

ХӨРӨНГӨ ОРУУЛАХ БҮТЦЭЭР:




2019 ОНЫ ТӨСӨВ ба АГААРЫН БОХИРДОЛ

2019 ОНД ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР:

- 2019 онд гадаадын зээл, тусламжаар шинээр болон он дамжиж хэрэгжих нийт **23 төсөл хөтөлбөр** байна. Эдгээрийг нэгтгэж дүгнэвэл Улаанбаатар хотын эрчим хүч, ус, дулааны дэд бүтцийг сайжруулах замаар гэр хорооллыг барилгажуулахад чиглэсэн төсөл хөтөлбөрүүд дийлэнх нь байна.
- Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төсөл хөтөлбөрийн нийт төсөвт өртөг нь 1,733.32 сая ам.доллар ба үүнээс **1,669.62 ам.доллар нь зээлээр, 63.7 сая ам.долларын санхүүжилт нь буцалтгүй тусламж** байна.
- 2019 онд хийгдэх санхүүжилтийн дүнг хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдийг агаарын бохирдлын эх үүсвэрийн бүтцэд шилжүүлсэн байдлаар тооцвол:
 - **Улаанбаатар хотын дэд, бүтэц - 48 хувь**
 - Гэр хорооллыг хөгжүүлэхэд - 4 хувь
 - Орон сууцжуулах төсөл хөтөлбөр - 11 хувь
 - Тээврийн хэрэгсэл - 7%
 - Бусад (хог, хаягдал ус) - 31%
- Санхүүжүүлэгч түнш буюу улс орноор нь үзвэл хамгийн их санхүүжилтийг **Азийн Хөгжлийн Банк** (80.45 сая ам.доллар), дараа нь **БНХАУ** (71.9 сая ам.доллар) байна.

2019 ОНЫ ТӨСӨВ ба АГААРЫН БОХИРДОЛ

ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ БА АГААРЫН БОХИРДЛЫН ХЭМЖЭЭ: /2011-2019/




Графикаас харахад 2016-2017 онуудад улсын төсвөөс зарцуулсан мөнгөн дүнгийн хэмжээ буурсан нь агаарын бохирдлын PM10, PM2.5, SO2 өсөхөд нөлөөлсөн байж болзошгүй байна.

Эх сурвалж: Нийслэлийн агаарын тайлан /Цаг, уур орчны шинжилгээний газар/, СЯ /2011-2019 төсөв/

2019 ОНЫ ТӨСӨВ ба АГААРЫН БОХИРДОЛ

АГААРЫН БОХИРДЛЫН ХЭМЖЭЭ: /2017-2018 он, 10-р сарын эхний 7 хоногийн байдлаар/



2018 оны 10-р сарын эхний 7 хоногийн үзүүлэлтийг 2017 оны өнгөрсөн мөн үетэй харьцуулсан байдлаар харвал:

Хүхэрлэгийн хэмжээ SO_2 36.4%-иар, $PM_{2.5}$ -ийн хэмжээ 35.6%-иар, PM_{10} -ийн агаарт агуулагдах хэмжээ 2.7%-иар тус тус бага байна.

US Embassy Ulaanbaatar Mongolia (Air Quality)

$PM_{2.5}$, 10/07/2018 22:00, "0.016", mg/m^3

<https://www.stateair.mn/history.php>

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын тайлан 2017-2018 он

2019 ОНЫ ТӨСӨВ ба АГААРЫН БОХИРДОЛ

ДУГНЭЛТ:

- Агаар, орчны бохирдлын буруулах Үндэсний хөтөлбөр батлагдсантай холбогдуулан улсын төсөвт **суух санхүүжилтийн эх үүсвэр маш тодорхой** болсон нь энэ жилийн төсвийн төслийн онцлох зүйл юм.
- БОАЖЯамны харъяанд **Агаар, орчны бохирдлыг бууруулах агентлаг**, мөн НЗДТГ-ын харъяанд **Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах газар** гэсэн 2 тодорхой байгууллагатай болж зохион байгуулагдсан.
- 2019 онд Улс төсөв, орон нутгийн төсвөөс 106.4 тэрбум төгрөг, Агаар бохирдуулсны төлбөрөөс 22 тэрбум төгрөг, Ус, рашаан ашигласны төлбөрөөс 26.5 тэрбум төгрөг, нийт 154.7 тэрбум төгрөгийн санхүүжилт бүрдүүлэхээр болсон нь өнгөрсөн **2011-2018 онуудад төсөвлөсөн төсвөөс 23 хувиар илүү** байна.
- Засгийн газраас төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны зорилтот түвшний үзүүлэлтэд агаарын бохирдлын бууруулах 3 арга хэмжээг оруулж өгсөн байна.
 1. Агаар бохирдуулагч бодисыг 2016 оны 12-р сарын дундаж үзүүлэлттэй харьцуулахад **25 хувиар бууруулсан байх.**
 2. Шөнийн цахилгаан эрчим хүчний хөнгөлөлтөд **150,000 гэр хорооллын айл өрхийг хамруулсан байх.** Энэ нь нийт гэр хороололд амьдардаг өрхийн 75 хувь.
 3. Гэр хорооллын айл өрхүүдийг цахилгаанаар халаах боломжийг нийт **41,200 өрхийг хамруулах.** Энэ нь нийт гэр хороололд амьдардаг өрхийн 20.5 хувь

2019 ОНЫ ТӨСӨВ ба АГААРЫН БОХИРДОЛ

ДҮГНЭЛТ:

- Дээрхи зорилтын хүрээнд төсвийн зарцуулалтын хийх талаар БОАЖЯам Олон нийтэд зориулж хийсэн хэвлэлийн бага хурлын үеэр мэдээллийг нэгтгэж үзвэл агаарт агуулагдаж буй хорт нэгдлийн хэмжээг бууруулах богино хугацааны арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн байна. Үүнд:
 1. 16.4 тэрбум төгрөгийг гэр хорооллын айл өрхийн шөнийн цахилгааны үнийн хөнгөлөлтөд;
 2. 54.3 тэрбум төгрөгийг нийт 100,000 гэр хорооллын өрхийн зуухны янданд шүүлтүүр суулгахад;
 3. 22.5 тэрбум төгрөгийг нийслэл хотод байгаа уурын болон нам даралтын 3000 зууханд филтер тавихад,
 4. 54.7 тэрбум төгрөгийг сайжруулсан түлшний үйлдвэрлэл татаас олгоход;
- Засгийн газраас Ипотекийн зээлийн санхүүжилтэд зориулж **115 тэрбум төгрөгийг** эх үүсвэрийг суулгасан. Энэ дунджаар 1650 ипотекийн зээлийг санхүүжүүлэх эх үүсвэр юм.
- 2019 оноос Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр зөвхөн нийслэл үйл ажиллагаа явуулаад зогсохгүй мөн орон нутагт төсөв хуваарилахаар төлөвлөсөн.
 1. Олборлосон түүхий нүүрсэнд ногдуулах агаарын бохирдлын төлбөрийн орлогын 50%-ийг (22 тэрбум төгрөг);
 2. Газрын тосны тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 30% (838,9 сая төгрөг);
 3. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50% (33 тэрбум төгрөг);

2019 ОНЫ ТӨСӨВ ба АГААРЫН БОХИРДОЛ

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

2011-2018 онуудад Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр улсын төсөвт суулгаснаар **119 тэрбум төгрөг** зарцуулсан боловч хариуцан хэрэгжүүлэх нэгж байхгүй байсан зэрэг нь төсвийн зарцуулалтыг хянах боломжгүй, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг хэмжих, дүгнэх нөхцөлгүй болгосон бол **2019 оны төсөв нь бүхэлдээ Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр томоохон өөрчлөлт, шинэчлэлт болох төсвийн төсөл** болсон байна.

Өөрөөр хэлбэл санхүүжүүлэх үүсвэр нь тодорхой, захиран зарцуулах нэгж нь тодорхой, үр дүнг хэмжих зорилтот үзүүлэлт тодорхой, мөн нилээдгүй олон ажлыг хийж хэрэгжүүлэхээр зөвхөн **Улаанбаатар хотод бус орон нутгийг хамарч чадсанаараа онцлогтой** гэж үзэж байна.



АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА.

УЛААНБААТАР ХОТЫН АГААРЫН БОХИРДОЛ БА 2019 ОНЫ ТӨСӨВ

Судлаач: Б.Энхбаяр